



**ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН  
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ**

2020 оны 07 сарын 08 өдөр

Дугаар А/284

Арвайхээр

Эрх шилжүүлэх тухай


Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.5, 14.4, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 45 дугаар зүйлийн 45.6, Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2020 оны “Хөрөнгө оруулалтын эрх шилжүүлэх тухай” А/48 дугаар тушаалыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Монгол Улсын 2020 оны төсвийн тухай хуулийн 2 дугаар хавсралтын V.2.1-д батлагдсан “Монгол Улсын төв цэгийн засвар, тохижилт (Өвөрхангай, Бүрд сум)-д батлагдсан 200,000,000 (хоёр зуун сая) төгрөгийн худалдан авах ажиллагааг зохион байгуулах эрхийг дээрх сумын Засаг дарга (Г.Баярмөнх)–д шилжүүлсүгэй.

2.Худалдан авах ажиллагааг Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу зохион байгуулж, тендерийн бичиг баримтыг бүрдүүлж ажиллахыг Засаг дарга (Г.Баярмөнх) –д үүрэг болгосугай.

3.Санхүүжилтийг хуваарийн дагуу олгохыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтэс (Д.Нэмэхбаяр)-т зөвшөөрсүгэй.

ОРЛОГЧ



О.БАТЖАРГАЛ

011100629